



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 292

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 113,675,924.45 (нэг зуун арван гурван сая зургаан зуун далан таван мянга есөн зуун хорин дөрвөн төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлага худалдааны зарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудсанд байршуулах;

2.3. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.4 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



0000549

C:\2019.07.22 16r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт
2019 оны 07 дугаар сарын 23
292 дугаар тогтоол

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Автомашины марк, Балансын дугаар, Хүндэтгэлт, хөдөлгүүр, Хүндэтгэлт дугаар	Үйлдвэр лэсэн/ ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	X
Автобус Грейс 90-08 ДОО, Хүндэтгэлт, fr3k563463, p3-	2003/2009	220463	17,411,178.0	17,411,178.0	0	0	
Хүндэтгэлт", 80-56 сгай, fd3hka10975	1989/2008	195000	22,000,000.0	22,000,000.0	0	0	
Трактор", 48-13 ай, 52366, 33180	2003/2003	90000	30,210,201.0	30,210,201.0	0	0	
Хүндэтгэлт-80", 85-65 удлын, HDJ81-	1993/2013	60061	22,000,000.0	22,000,000.0	0	0	
ABOVER Авто 9-86 CYA, тусгай, 21136	1993/2012	17398	8,000,000.0	8,000,000.0	0	0	

Автомашинны марк, улсын дугаар, уулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн/ ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	X
322069", 15-48 CУА, ын, 80455571, 946	1998/1998	45543	14,054,545.5	14,054,545.5	0	0	
Нийт дүн			113,675,924.45 (нэг зуун арван гурван сая зургаан зуун далан таван мянга есөн зуун хорин дөрвөн төгрөг дөчин таван мөнгө)	113,675,924.45 (нэг зуун арван гурван сая зургаан зуун далан таван мянга есөн зуун хорин дөрвөн төгрөг дөчин таван мөнгө)			(a